



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 01174

Улаанбаатар хот


Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын
алба ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/165 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 88,950,000.0 /наян найман сая есөн зуун тавин мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай каунти маркийн 53-42 БРА улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын алба ОНӨААТҮГ /Б.Мөнх-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын алба ОНӨААТҮГ /Б.Мөнх-Эрдэнэ/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Тушаал авто-2020

115010000353